

Мэдээлэл

## ГОТОР ОВООНЫ ХОВОР-ХОЛИМОГ МЕТАЛЛЫН ЭПИТЕРМАЛ ХҮДЭРЖИЛТИЙН ТУХАЙ

Д. Доржготов

Монгол Улсын Их Сургууль

2007 онд Адамас майнинг компаниас Чандгана талын мезозойн хотгорын баруун захад хийсэн эрлийн ажлаар Готор овооны холимог металл хэмээн иргэгдсэн илрэлийг судалж алт-мөнгө-хартугалга-вольфрамийн бага температурын гидротермал буюу эпитермал хүдэржилт болохыг тоогоосон. Готор овооны илрэлийн талбайд дунд-доод триасын настай дашбалбар формацийн тунамал бялхмал чулуулаг тархсан ба тэр нь эх газрын рифтоген хотг оргүүссэн риолит, риолит порфир, риодакит, элсэн чулуу, алевролитаас бүрдсэн. Элсжин ба риолит нь хагарлын дагуу цайж хувирсан заримдаа хүчтэй цахиржсан байдал.

Хүдрийн биег нь цахиржсан элсжин ба риолитол агуулагдсан өөр хоорондоо зорлогдо байрласан 120-250м ургтай, 0,2-1,8м зузаантай янз бүрийн охртой хааяа галенитийн шигтгээгэй кварц-халиедон-карбонатийн сулууд ба 0,3x2,3м-0,8мх3,1м хэмжээтэй шток холбөрийн бистүүдээс бүрдсэн. Судлууд нь уртрагийн дагуу чиглэлтэй босоо байрлалтай, газрын гадаргал сайн мөрдөгддөг. Хүдрийн найрлагад төмрийн усанисэл, алтын тоосонцор мөхлөгүүд, галенит, халькозин, куприт, пирит, хааяа азурит, перуссит, малахит, аранжин зэс, шеелит зэрэг хүдрийн эрдсүүд, кварц, кальцит, халиедон зэрэг хүдрийн бус эрдсүүд тогтоогдсон.

Агуулагч элсжин нь жижиг-дунд нийрхэгтэй, хэвтээдүү байрлалтай, саарал онгөтгэй. Судлуудын орчимд элсжин нь хүчтэй цахиржиж уртрагийн дагуу чиглэлтэй 300м орчим өргөнтэй бүсийг үүсгэсэн байна.

Хүдрийн бистүүдээс авсан ховилон ба штуфи дээжүүлийн химийн шинжилгээгээр Pb-1-10,8%, W-0,05-4,61%, Cu-0, 5% хүртэл, алтын спектр шинжилгээгээр алт 0,01-0,7г/т, мөнгө 10-100г/т агуулгатай гэж тогтоогдсон.

Судлаачид /Обелинский нар, 1987/ Дорнод Монголын энтермал үүсэлтэй ашигт малтмал нь /U, Pb, Au, Ag, W, CaF<sub>2</sub>, Mo/ хожуу мезозоийн бимодаль бялхмал чулуулаг ба экстрэзив биетүүдгэй холбоотой гэж үзжээ. Илрээс урагш дээрхи төрлийн чулуулагт хамрагдах дэлбэрэлтийн брекчийн судал, шток хэлбэрийн биет тогтоогдсон бөгөөд тэдгээр биетүүдийн нөлөөгөөр Готор овооны алт-мөнгө-хартугалга-вольфрамын энтермал гаралтай хүдэржилт үүссэн байх бололцоотой учир цаанид нарийвчлан судлах шаардлагатай.

Судалгааны үр дүнг урьдчилсан байдааар дүгнэхэд Готор овооны илрэл нь хүдрийн эрдсийн найрлага, хүдэржилт орчмын хувирал зэрэг гол шинжүүдээрээ энтермал үүсэлтэй хартугалга-вольфрамын төрлийн хүдэржилтэд хамрагдана. Хүдэр нийлмэл найрлагатай, олон ашигт компоненттэй учир эрлийн хувьд ихээхэн сонирхолтой.

Дэлбэрэлтийн брекчийн биетүүдийг нарийвчлан судалж хүдэржилтэй холбоотой эсэхийг тогтоох нь чухал ач холбогдолтой.

Чандгана талын хожуу мезозоийн хотгорын захын өргөгдсөн хэсгүүдэд үүссэн янз бүрийн чиглэлтэй хагарлууд алт, мөнгө, хартугалга, вольфрамын энтермал хүдэржилтийн хувьд структурийн шалгуур болж байгаа тул энэ хотторын захын хэсгүүдэд судалгаа хийх нь зүйтгэй гэж үзэж байна.

## ГЕОЛОГИЧДЫН ОЛОН УЛСЫН ХУРАЛ

2008 оны 8 сарын 15-16 -ны өдрүүдэл “Цэrdийн үсийн Азийн уур амьсгал” сэдэвт олон улсын геологичдын хурал Улаанбаатар хотод МУИС-ийн дугуй зааланд болно. Хурлыг Монголын Шинжлэх Ухааны Академи, Монгол Улсын Их Сургуулийн Газарзүй-Геологийн Факультетийн Геологи Минералогийн тэнхим, Палеонтологийн төв, Шинжлэх Ухаан Технологийн Сан зохион байгууна. Хээрийн экспурс нь Өмнөговь аймгийн нутагт тархсан Цэrdийн үсийн диназаврын олдвор бүхий газруудад 8 сарын 17-20-ны хооронд явагдана. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://igcp507.kopri.re.kr/> сайт руу орж үзүү.